




БАТЛАВ
“Элемент” ХХК-ний
Брөнхий захирал:

 З.Баярсайхан /

УИКН5798 2100061



БАТЛАВ
“Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв” -ийн
Брөнхий захирал:

 /Н.Эрдэнэбаяр/

УЗИН 0116

**Эрүүл мэндийн байгуулагуудын тусгай хог хаягдлыг тээвэрлэх,
халдвартгуйжүүлэх, устгах, аюулгүй болгох**

Гэрээ №Я16/03

2016 оны 01 сарын 11. өдөр

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Нэг талаас “Элемент” ХХК /цаашид гүйцэтгэгч гэх/ төлөөлж **Брөнхий нягтлан бодогч** албан тушаалтай **Н.Түвшинжаргал** нэгээ талаас “**ЦССҮТөв**” /цаашид захиалагч гэх/ -ыг төлөөлж **Брөнхий нягтлан бодогч** албан тушаалтай **Д.Гүнжээ** Бид харилцан тохиролцож МУ-ын Иргэний хууль, Ахуйн болон Үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хууль, Эрүүл Мэндийн Байгууллагын хог хаягдлыг цуглуулах,ангилах .хадгалах, тээвэрлэх, устгах заавар” болон ЭМСС-ын 158 тоот тушал, А320/305 тоот тушаал, ЭМСС-ын 459 тоот тушаал,Байгаль орчинь холбогдох хууль,дүрэм журмыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

1.2 Энэхүү гэрээний зорилго нь гүйцэтгэгч тал нь эмнэлгээс гарч байгаа аюултай болон эрсдэлтэй хог хаягдлыг гэрээнд заасан хугацаанд ачиж тээвэрлэх,халдвартгуйжүүлж устгах, захиалагч тал нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөх,болон байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулж хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

Хоёр. Захиалагч талын эрх үүрэг

2.1 Гүйцэтгэгч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах

2.2 ЭМБ-аас гарч байгаа аюултай болон эрсдэлтэй хог хаягдлыг цуглуулах тээвэрлэх аюулгүй болгох зааварчилгааг зөрчсөн тохиолдолд шаардлага тавих.

2.3 Хог ачуулсан тээврийн тооцооны хуудсанд ажилласан цаг, рейсийг бичиж, гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулах.

2.4 Хог хаягдал тээвэрлэж устгасны хэлсийг гэрээнд заасан хугацаанд төлөх

2.5 Хог хаягдлаа ачиж тээвэрлэх захиалга өгсөн үед тээврийн хэрэгсэл очиход хариуцсан ажилтнаа байгууллага дээрээ байлгаж, хог ачилтанд хяналт тавих.

2.6 гарч байгаа аюултай , эрсдэлтэй хог хаягдлыг тасаг цэгүүдээсээ нэг цэгт цуглуулан, зориулаалтын байранд хадгалан хүлээлгэн өгөх.

2.7 Гүйцэтгэгчийн устгал хийх явцтай танилцаж хяналт тавиж болно.

2.8 Хог хаягдлыг хүлээлгэж өгөхдөө хэмжээг бодитоор хэмжих.

2.9 ЭМС-ын 158 тоот тушаалын дагуу бэлтгэл хийн хүлээлгэн өгөх

Гурав. Гүйцэтгэгч талын эрх үүрэг

- 3.1 Захиалагч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах.
- 3.2 Хог хаягдал тээвэрлэсний хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулахыг шаардах.
- 3.3 Ачиж тээвэрлүүлэх хаягдлыг зориулалтын сав баглаа боодолтой байхыг шаардах.
- 3.4 Гэрээний дагуу хог хаягдлаа ачуулаагүй, хог шатаасан, бусад тээврийн хэрэгсэлд дайж явуулсан зэрэг тохиолдолд зөрчлийг арилгуулахаар шаардлага тавих.
- 3.5 Хог хаягдал ачиж тээвэрлэх, тээврийн хэрэгслийг ажилд бэлэн байлгах, захиалагч талын хог хаягдлыг гэрээнд заасан хуваарийн дагуу хугацаанд нь саадгүй тээвэрлэх.
- 3.6 Эмнэлгийн хог хаягдлыг зориулалтын устгалын төвд аваачиж устгах, аюулгүй болгох.
- 3.7 Гүйцэтгэгч талын буруутай үйл ажиллагаанаас тээвэрлэлт saatаж хог хаягдал ихээр хууримтлах, биологийн гаралтай хог хаягдал ихээр гарсан тохиолдолд хуваарьт зааснаас бусад цагаар нэмэгдэл хүч гарган тээвэрлэж, халдвартгуйжүүлж устгах.
- 3.8 Тухайн байгуулага дээр гарсан онцгой нөхцөл байдлын улмаас ажиллах тохиолдолд гэрээ, ЭМС-ийн тушаалд заагдсаны дагуу үүргээ биелүүлэх үүргэтэй.

Дөрөв. Тээвэрлэх ачааны хэмжээ, тээвэрлэх хугацаа,

төлбөр тооцоо

- 4.1 Үйлчилгээний төлбөрийн зардалын жишигийг сар тутмын тусгай зориулалтын эмнэлгийн гаралтай хог хаягдлыг хийх сав баглаа боодлын үнийг багтаахгүй устгалын төлбөр нь хуучин ЭМССайдын 93 тоот тушаалын дагуу сарын 140 000/- Нэг зуун дөчин мянган / төгрөг
- 4.2 Хог хаягдлыг татан авах цаг хугацааны хуваарь нь 7 хоногт хуваарийн дагуу татан авалт хийнэ..
- 4.3 Үйлчилгээний төлбөрийг / сар, улирал, жил/ бүрийн эхний 10 хоногийн дотор төлнө.

Тав. Талуудын хүлээх хариуцлага

- 5.1 Энэхүү гэрээний 4.3-д заасан хугацаанд захиалагч тал үйлчилгээний төлбөрөө төлөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутам үнийн дүнгийн 0,2 хувиар алданги тооцож төлнө.
- 5.2 Гүйцэтгэгч тал нь уг гэрээний 3.4,3.5 дахь заалтыг зөрчсөн тохиолдолд уг гэрээний хуваарийн дагуу нөхөн хог хаягдлыг хүлээлгэн өгч устгуулахыг шаардах эрхтэй.

5.3 Захиалагч тал графикт хугацаандaa хог хаягдлаа гаргаж өгөөгүй, машин орж хогийг авах боломжгүй , зориулалтын стандартын өгсөн сав баглаа боодолд хийгээгүй тохиолдолд мэрэгжлийн хяналтын байгууллагад хандан арга хэмжээ авахуулна.

5.4 ЭМСС-ын А320/305 тоот тушаал, ЭМСС-ын 158 тоот тушаалуудыг биелүүлээгүй тохиолдолд Мэргэжлийн хяналтын байгууллага, Халдварт өвчин судлалын үндэсний төвд хандаж гарсан зөрчил дутагдлыг арилгуулна.

Зургаа. Бусад

6.1 Гэрээнд заасан болон бусад зүйлийн талаар маргаан гарвал талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэх бөгөөд эс зөвшөөрөвлө /шүүх, арбитар/-аар шийдвэрлүүлнэ.

6.2 Энэхүү гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд талууд гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болно. Гэрээг, 1 жил буюу 2016 оны 01 сарын 01ны өдрөөс 2016 оны 12 сарын 31-ны өдөр хүртэл байгуулав

6.3 Энэхүү гэрээ нь гэрээний хугацаа дуусхаас 10 хоногын өмнө эсвэл гэрээг талууд харилцан зөвшөөрөлцөх хугацаанаас өмнө цуцлахаар саналыг бичгээр мэдэгдэнэ

6.4 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож , нэмэлт гэрээг зөвхөн бичгээр хийж, гарын үсэг зурсанаар хүчин төгөлдөр болно.

6.5 Тухайн сард тооцогдсон мөнгөн дүнгийн баримт, хогны бүртгэл зэрэг нь гэрээний салшгүй хэсэг болно.

Долоо.Гэрээ байгуулсан :

“Элемент” ХХК - ийг төлөөлж:

Ерөнхий нягтлан бодогч

/ Н. Түвшинжаргал /

Харилцах утас : 88063992,

Дуудлагын утас : Дорж / мен/ 88057656

Харилцах банк : ХХБ 804-р салбар

Данс:404054323

Хаяг : СХД-ийн 26-р хороо Их наран

“ЦССҮТөв “-ийг төлөөлж:

Ерөнхий нягтлан бодогч: ажилтай

/ Д.Гүнжээ/

Харилцах утас: 99124995,

Харилцах банк: Төрийн сан

Хаяг . СБДүүрэг өөрийн байр